

Ү.ТУЯАГИЙН "МОНГОЛ ХЭВЛЭЛИЙН ТҮҮХ"-ИЙГ ШҮҮМЖЛЭХ НЬ

На.Сэцэн*

* Өвөр Монголын Их Сургуулийн номын сангийн дэд судлагч

Түлхүүр үг: Чингисийн чулууны бичиг, эртний ном бичгийн ерөнхий гарчиг, хэвлэлийн байгууламж, монгол хэвлэлийн ажиллагааны жам хууль

Товч агуулга: "Монгол хэвлэлийн түүх" бол Хятад дахь анхны монгол хэвлэлийн түүхийн тухай бие даасан бүтээл болно. Тус номд Бээжин, Өвөр Монгол, Халх, Ойрад, Буриад зэрэг газар орны монгол хэвлэлийн ажиллагааг голлон судалсан. Бүх үзэгдлийн хараалал хийгээд ойр үзэгдлийн ажиглалтын уялдаа бол "Монгол хэвлэлийн түүх"-ийн бичлэгийн хамгийн товойсон онцлог болно. Тэр нь уртраг өртрөг хэлбэрээр торчилсон системийг бүрэлдүүлж, монгол хэвлэлийн түүхийг бүх талаар хайн тодорхойлоход тус үзүүлэхийн хамт судалгааны ажил гүнзгийрч буйг батлаж чадсан юм.

Монгол ном, хэвлэлийн түүхийн судалгаа бол монгол түүх судлалын нэгэн салбар судалгаа юм. Монгол үсэг бичиг бий болсон тэр эринээс монгол ном, хэвлэлийн ажиллагаа эхэлсэн гэж бодвол одоо болоход монгол хэвлэл нь нэгэнт мянгаад жилийн түүхийг сундалласан байна. Гэвч материалын хомсдлоос болоод монгол ном, хэвлэлийн

түүхийн талаар өнөөдөр болтол тусгай судалгааны бүтээл гараагүй, тэр нь зөвхөн эл сурвалж бичигт алдаг оног тэмдэглэгдсэн төдий л байв. Монгол ном, хэвлэлийн түүхт материал хомсдсон шалтгаан нь монголчуудын амьдралын арга маяг ба монголчуудын туулсан ер бусын түүхэн замналтай холбогдоно. Монголчуудын нүүдлийн амьдралын хэлбэр бусдыг байлдан дагуулсан ба бусдад дайлагдан түрэмгийлэгдсэн дайнд Монголын нийгмийн талхлагдаж үлдэж хоцорсон эртний ном бичгийн тоо тун цөөхөн. "Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчгийн тоо бүртгэл"-ийг үндэслэвэл 1949 оноос өмнө Дундад улсад бичигдэж, сийлэгдэж барлагдсан бөгөөд одоо болтол хадгалагдаж байгаа 13115 эртний ном бичиг байна. Хоцрон үлдсэн эдгээр тоотой хэдэн ном бичгийн сураг зангиас нэг үндэстний ном, хэвлэлийн ажиллагааны бүх дүр зургийг гаргахад хэцүү юм.

Ү.Туяагийн хэвлүүлсэн "Монгол хэвлэлийн түүх" бол Хятад дахь хамгийн анхны монгол ном, хэвлэлийн түүхийн тусгай бүтээл болно. Ү.Туяа Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд он удаан жил ажилласан нэгэн. Тэрээр 1995 оноос эхлэн монгол ном бичгийн судалгаанд

гар дүрж, Монголын эртний ном бичиг, хэвлэлийн түүхийг системчлэн судлахыг зорилго болгожээ. 2005 онд тэрээр "Монгол үндэстний хэвлэлийн түүх"-ээ улсын нийгмийн шинжлэх ухааны төслийн судалгааны сэдвээр батлуулж, тус ажлыг 2008 онд амжилттай гүйцэтгэжээ. "Монгол хэвлэлийн түүх" бол "Монгол үндэстний хэвлэлийн түүх"-ийн засалт эхийн хэвлэл болно. Тус номын бичлэгийг хэдийгээр богинохон хугацаанд гүйцэтгэсэн боловч түүнд орсон нөр их хөдөлмөрийг зөвхөн хэдэн жилийн хүч хөдөлмөрөөр хэмжиж болохгүй. Харин зохиогчийн номын санд он удаан жил бясалгал хийсний үр дүн гэж үзвэл зохино.

Бүх үзэгдэлийн харьяалал хийгээд ойр үзэгдлийг ашиглан, тэдний уялдаа холбоог гаргасан нь "Монгол хэвлэлийн түүх"-ийн бичлэгийн хамгийн гол онцлог болно. Эрдэмтэд Монгол ном, хэвлэлийн түүхийг X-XIII зуунаас үүсэлтэй гэж үздэг. Монгол ном, хэвлэлийн түүхийн үүсэл нь монгол үсэг бичгийн үүсэлтэй шууд холбогдоно. XIII зуунд монголчууд найман аймгийн Тататунгааг олзолж, түүнээр уйгаржин монгол үсгийг бүх Монголд дэлгэрүүлсний дараа Монголын нутагт уйгаржин монгол үсгээр сийлсэн "Чингисийн чулууны бичиг", "Монголын нууц товчоо" өвлөгдөн үлджээ. Мөн тэр эртнээс монгол ном, хэвлэлийн түүх, түүний эх урсгал нэмэгдэж, түүхийн урт голдролоор эдүгээ улам боловсронгуй болж, төгөлдөрсөн юм. Энэхүү үйл явц монгол ном, хэвлэлийн түүхийн бүх үзэгдлийг хамарч, түүнийг бүрэн бүтнээр нь илрүүлснээр чухал ач холбогдолтой юм.

Монголчууд боловсрон цогцлох түүхэн явцдаа уйгаржин, дөрвөлжин, альгаль, тод, вагиндра, соёмбо, кирилл зэрэг монгол үсгийг хэрэглэж байсан

билээ. Эдгээр үсэг нь нийгэм түүхийн олон зүйлээс шалтгаалан зарим нь удалгүй орхигдож, зарим нь хэдийгээр он жилийн саалтанд хэсэг бусаг мөрөө тамгалан хоцроосон ч хожим нь мөн балран замхрав. Үүнд уйгаржин үсгийн амьдрах чадвар бусдаасаа илүү байж, чулуу, үйс, бөс, арьс, цаас зэрэг ачаалагчид монгол үндэстний боловсоныг дуурайлган тэмдэглэснээр манай эринд хүрчээ. "Дундад улсын эртний ном бичгийн ерөнхий гарчиг"-т бүртгэгдсэн ном бичгийн бар хэвлэлийг шинжилбэл эдгээр эртний ном бичиг нь бараг бүгдээрээ уйгаржин монгол үсгийн хэвлэл байжээ. Эдгээр ном бичиг нь Дундад улсын бүх номын сан, Монгол улсын номын сан, Санкт-Петербургийн их сургуулийн номын сан, Копангагений вангийн номын сан, Японы Тояа Бунко, Хангарийн шинжлэх ухааны номын сан зэрэг газарт хадгалагдаж байна. Үүнээс үзвэл "Монгол хэвлэлийн түүх"-ийг уйгаржин монгол үсгээр хэвлэгдсэн ном бичгийн түүх гэж үзэж болно.

Монгол ном, хэвлэлийн түүхээс үзэхэд Бээжин, Өвөр Монгол, Халх, Ойрад, Буриад зэрэг газар орны монгол хэвлэлийн ажиллагаа голчлон судлагдсан байна. Тухайн үед эдгээр газар нь монгол ном, хэвлэлийн ажиллагааны гол суурин байснаас судлаачдын хараанд өртсөн нь тодорхой. Үүний зэрэгцээ Оросын Казань, Санкт-Петербург, Иркутск, Владивосток дахь монгол хэвлэл, Английн Лондон дахь монгол хэвлэл зэрэг өрнө дахины монгол хэвлэлийн ажиллагаа, мөн Дундад улсын ариун номын хэвлэлийн газар дахь монгол хэвлэл, Шанхай дахь өрнө дахины Христосын шашинтны монгол хэвлэл, англи ба гадаадын ариун номын нийгэмлэгийн Шанхай дахь хэвлэлийн

газрын монгол номын хэвлэлийн ажиллагаа нь судлаачдын хараанд өртөж, голчилсон судалгааны нөхвөр болжээ. Голдлого хийгээд нөхвөрөөр бүрэлдсэн бүх үзэгдлийн хамаарал нь тус судалгааны нэгэн бүрэн бүтээл монгол хэвлэлийн түүхийн судалгаа болтлоо өргөжжээ.

Бүх үзэгдлийн хамаарал нь бүтцийн хувьд "Монгол хэвлэлийн түүх"-ийн араг ясыг цогцлоож өгсөн бол ойр үзэгдлийн ажиглалт нь "Монгол хэвлэлийн түүх"-д судалгааны системийг бүрэлдүүлж өгсөн юм. Тус түүх судалгаанд өмнөх судалгааны хүрээг тэлсэн бол хойнох нь судалгааг гүнзгийрүүлж үзэх боломж өгснөөрөө онцлогтой. Тус судалгаа нь дараах хоёр дэд системийн хүрээнд хийгджээ. Үүнд:

1. *Хэвлэлийн байгууламж, хэвлэгч, хэвлэгдэхүүний судалгааны систем*

"Монгол хэвлэлийн түүх" нь гол төлөв Их Монгол улсын үеийн монгол хэвлэл, Юань улсын үеийн монгол хэвлэл, Мин улс, Умард Юаний монгол хэвлэл, Чин улсын үеийн монгол хэвлэл, Иргэн улсын үеийн монгол хэвлэлийг түүхчлэн тодорхойлохыг хичээсэн байна. Үүнд эл шатан дахь хэвлэлийн байгууламжийг нийгэм-түүхийн шүүмжлэлийн аргаар нотлон тодорхойлох, хэвлэлийн зүтгэлтнийг намтар зүйлийн судалгааны аргаар өгүүлэн үзүүлэх, монгол хэвлэгдэхүүнийг бар зүйн судалгааны аргаар нотлох буюу агуулгын задлал хийх нь

тус судалгааны чухал үүрэг болов. Нийгмийн тогтолцоо нь хэвлэлийн ажиллагааны үүсэл, хөгжил хийгээд уналтад нөлөөлж байдаг. Үүнийг Юань улс мөхсөний дараа феодалуудын хооронд дотоодын дайн байнга дэгдэж, Монголын нийгмийн байгууламжинд тогтвор алдагдсанаас энэ үеэр олигтой монгол ном зохиол гараагүй мөртлөө

өнгөрсөн үеийн бүтээсэн бодисын болон оюуны соёлоо ч ихээхэн үрэгдүүлсэн үзэгдэл үүнийг гэрчилнэ. "Монгол хэвлэлийн түүх"-д хэвлэлийн байгууламжийг нотлон тодорхойлоход нийгэм-соёлын орчин ахуйд эдгээр хэвлэлийн байгууламж, эсвэл хэвлэлийн гол суурин газрын буй болсон ба түүний хэвлэлийн ажиллагааг

«
Нийгмийн тогтолцоо нь хэвлэлийн ажиллагааны үүсэл, хөгжил хийгээд уналтад нөлөөлж байдаг. Үүнийг Юань улс мөхсөний дараа Монголын нийгмийн байгууламжинд тогтвор алдагдсанаас энэ үеэр олигтой монгол ном зохиол гараагүй мөртлөө өнгөрсөн үеийн бүтээсэн бодисын болон оюуны соёлоо ч ихээхэн үрэгдүүлсэн үзэгдэл үүнийг гэрчилнэ.

»
системтэй өгүүлж тодруулав. Энэ нь түүхэн дэх монгол хэвлэлийн байгууламжийн эхлэл хийгээд төгсгөлд тодорхой тушаалт хийхэд ач тус үзүүлсэн байна.

Хэвлэгч бол хэвлэлийн ажиллагааны гол цогц болно. Тэд нь хэвлэлийн байгууламжийг удирдах ба ном бичиг найруулах, дармаллах, тараах ажилд шууд оролцож, хэвлэгдэхүүнийг бүтээхэд шийдвэрлэх нөлөө үзүүлдгээс хэвлэлийн түүх бичлэгт гол судлагдахуун болж дурдагдсан юм. "Монгол хэвлэлийн түүх"-д монгол хэвлэлийн ажиллагаанд төлөөлөгч хүмүүс болж тодорсон Юань улсын үеийн Цойж-Одсэр, Шаравсэнгэ, Биранашир, Умард Юань улсын үеэс Аюуш гүүш, Гунгаа-Одсэр, Самдансэнгэ, Чин улсын үеэс

Ролбийдорж, Билгийн далай Лувсан-чүлтэм, Иргэн улсын үеэс Тэмгэт, Хээшингэ, Бөххишиг нар дурдагдаж, тэдний ном хэвлэлийн үзэл санаа, ном хэвлэлийн ажиллагаа, мөн монгол хэвлэлийн үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэлийг нотлон тэмдэглэв.

Хэвлэгч бол хэвлэгдэхүүнийг үйлдвэрлэгч, хэвлэгдэхүүн бол ном хэвлэлийн ажиллагааны эцсийн үр дүн болно. Нэгэн иж хэвлэлийн түүхийг зохих утгаас судалбал тэр нь даруй нэгэн иж хэвлэгдэхүүний үйлдвэрлэлийн түүх мөн гэж үзэхэд буруудахгүй. Иймээс "Монгол хэвлэлийн түүх"-д хэвлэгдэхүүний судлал гол байрыг эзлэв. Тус хэвлэлд монгол ном хэвлэлийн түүхэн хөгжлийн үе шат бүрийн хэвлэгдэхүүний төрлийг ангилан судалж, бар зүй, найруулга зүйн үүднээс монгол хэвлэгдэхүүнд ачаалагдсан соёлын агуулга хийгээд барлал дэвтэрлэлийн онцлогийг харуулахыг хичээв.

Судлаач бээр нөгөө нэг тусгай туурвил "Монгол эртний ном бичгийн түүх" дэх монгол ном ангиллын уламжлалт арга болох "ухааны орон"-ы ангиллын аргыг мөрдөн, бас орчин үеийн гадаад дотоодын ном бичгийн ангиллын аргыг толилж, эдгээр аргыг харилцан уялдуулж монгол эртний ном бичгийн төрлийг ангилан танилцуулсан байна. Энэ арга "Монгол хэвлэлийн түүх"-ийн хэвлэгдэхүүний судалгаанд ч хэрэглэгдсэн байдаг. Тус номд монгол хэвлэгдэхүүнийг гүн ухаан, улс төр, цэргийн явдал, сурган хүмүүжил, шашин суртахуун, хууль цааз, зан заншил, аж төрөх, үг хэл, үсэг бичиг, хэл шинжлэл, толь бичиг, уран зохиол, анагаах ухаан, цаг улирлын тооны бичиг гэх мэтээр төрөлжүүлэн судалсан нь тухайн үеийн монгол ном бичгийн агуулгын онцлогт тохирох бөгөөд

одоо үеийн ном бичиг ангиллын арга зарчимд ч бүрэн нийцнэ.

2. Найруулах, дармаллах, тараах ажиллагааны судалгааны систем

Найруулах, дармаллах, тараах бол хэвлэлийн ажиллагааны гурван зангилаа болно. Хэвлэлийн ажиллагаанд найруулахаар товлож, дармаллахаар арга болгон, тараахаар хөөрөг болгодог. Үсэг бичгийн төгөлдөржил, боловсоны хөгжилт, оюуны соёлын бүтээгдэхүүний олшрол, үеийг сийрүүлэх материалын сайжрал, дармаллах мэргэжлийн илрүүлэл зэрэг нь хүн төрөлхтний хэвлэлийн хөгжлийг урагш ахиулав.

О н тооллын өмнө 1000 оноос он тооллын 1500 он хүртэл хугацаанд хүн төрөлхтний хэвлэлийн ажиллагаа үүссэнээс сүүлэрх сонгодог хэвлэлийн цаг эрин эцэслэж, хэвлэх ажиллагаа нь тусахаар бүрэн төгс, системтэй тусгайлсан нийгмийн бодит цогц болж бүрэлдэв. Энэ үеэс сонгодог хэвлэлийн цаг эринд нэгдмэл цогц байсан хэвлэлийн ажиллагаа нь найруулах, дармаллах, тараах эл салбарт нарийсан хөгжиж, хэвлэлийн салбарт томоохон өөрчлөлт гарсан юм. Монгол хэвлэлийн ажиллагаа нь XIII зуунд төлөвширч, сонгодог хэвлэлийн цаг эринийг дамжин шууд хэвлэлийн хувьсгалын шатанд шилжсэн онцлогтой. Түүнээс наашх эл хэвлэлийн шатанд хэдийгээр ном, бичиг хэвлэгдэхүүнийг олон тоогоор хэвлэн үлдээсэн үзэгдэл хойшлогдоогүй боловч монгол хэвлэлийн үйлсэд найруулах, дармаллах, тараах ажиллагааны систем бүрэлдэж, түүнийг "таван цул" бүтнээр урагш алхуулсан юм. Найруулах, дармаллах, тараах ажиллагааны системээр монгол хэвлэлийн ажиллагааны жам хуулийг хайн сүвэгчлэх нь "Монгол хэвлэлийн түүх"-д бас нэгэн судал-

гааны хараа сэхээ болжээ. Түүнд найруулан төгөлдөржүүлэх, хянан тохиолдуулах, ариутган шүүх зэрэг найруулах ажил, хэвлэлийн мэргэжил, номын үдээр бар хэвийн тохируулалт, үсгийн төрөл зүйл зэрэг дармаллах мэргэжил, засгийн ордноос тараах, сүм хийдээс тараах, үйлтгэлийн газраас тараах, хувийн хэвлэлийн газраас тараах зэрэг тараалтын арга маяг системтэйгээр судлагдаж, монгол хэвлэлийн хөгжлийн шат бүрийн онцлог нь тохиолдуулан монгол хэвлэгдэхүүний найруулах ажлын бүх зангиллыг тодруулан гаргав.

”**М**онгол хэвлэлийн түүх”-д хэвлэлийн байгууламж, хэвлэгч, хэвлэгдэхүүний судалгаа хийгээд найруулах, дармаллах, тараах ажиллагааны судалгаа нь

нэгэн тусгаар мөртлөө нэгдмэл цогц мөн. Тэр нь уртраг өргөрөг хэлбэрээр торчилсон системийг бүрэлдүүлж, монгол хэвлэлийн түүхийг бүх талаар хайн тодорхойлоход тус үзүүлэхийн хамт бас судалгааг гүнзгийрүүлж чадсан юм.

Резюме

Настоящая статья посвящена подробному анализу “Истории монгольской печати”, автором которой является Туяа, имеющая многолетний опыт работы в Библиотеке Института общественных наук Внутренней Монголии. “История монгольской печати” – первая самостоятельная работа по данной тематике, вышедшая в свет в КНР, и охватывает газеты и журналы, а также другие печатные издания, которые распространялись на территории Китая, Внутренней и Внешней Монголии, Бурятии и среди ойратов.